



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХУДАЛДААНЫ САЛБАР 2016



Улаанбаатар хот
2017 он

Танилцуулгыг хянан, тохиосон:

Дарга А.Ариунзаяа

Дэд дарга Ч.Баянчимэг

Эдийн засгийн статистикийн газрын дарга Э.Эрдэнэсан

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Эдийн засгийн статистикийн газрын ахлах шинжээч Л.Элбэгсайхан

Танилцуулгыг хэвлэлд бэлтгэсэн:

Төрийн захиргаа удирдлагын газрын Олон нийттэй харилцах хэлтэс

Хаяг: Засгийн газрын III байр, Бага тойруу-44, Улаанбаатар-11, Монгол Улс

Утас: 326414, 1800-1212

И-мэйл: information@nso.mn, Вэб хаяг: <http://nso.mn>, www.1212.mn.

АГУУЛГА

I.Оршил	2
II.Эдийн засагт худалдааны салбарын эзлэх байр суурь	
II.1 Хамрах хүрээ	4
II.2 Ажиллагчдын тоо, дундаж цалин	8
II.3 Нийт борлуулалт	12
II.4 Нийт үйлдвэрлэл	13
II.5 Нэмэгдэл өртөг	14
II.6 Хөдөлмөрийн бүтээмж	16
II.7 Худалдааны цэгийн тоо	17
III.Дүгнэлт	18

I. Оршил

Монгол Улсын болон бүс нутгийн бусад улс орнуудын эдийн засаг нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаатай холбоотойгоор мал аж ахуй, уул уурхай, барилгын болон худалдааны салбарт ихээхэн өөрчлөлтүүд бий болж байна.

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Энэхүү танилцуулгад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтүүд болох худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, ажиллагчид, цалин хөлс, нийт борлуулалт, нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртөг, хөдөлмөрийн бүтээмж, худалдааны нэг цэгт ногдох хүний тоо зэрэг мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Бөөний худалдаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эсвэл дараагийн шатны худалдаанд зориулан бөөнөөр борлуулах үйл ажиллагааг хамруулдаг бол харин жижиглэн худалдаанд хүн амын хэрэгцээнд зориулсан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийлгүй эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа багтдаг. "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал 4.0"-ын дагуу дотоод худалдааны салбар дараах 3 дэд салбараас бүрддэг. Үүнд:

1. "Авто машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ" дэд салбарт шинэ болон хуучин автомашин, мотоциклын бөөний болон жижиглэнгийн худалдаа, техникийн засвар үйлчилгээ, сэлбэг шатахууны жижиглэн худалдаа (код 45),
2. "Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа" дэд салбарт жижиглэн худалдаа, үйлдвэр, байгууллагын хэрэгцээнд барааг бөөнөөр нийлүүлдэг байгууллага, экспорт, импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа (код 46),
3. "Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ" дэд салбарт хүн ам, гэр ахуйн хэрэгцээнд зориулан дэлгүүр, лангуу, үүргийн болон захиалга, дуудлагаар бараа худалдах үйл ажиллагаа (код 47) зэрэг багтана.

Танилцуулгад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтүүдийг улс, салбар, бүс, аймаг, нийслэлээр тодорхойлж, зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай улсын худалдааны салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.



II. Эдийн засагт худалдааны салбарын эзлэх байр суурь

II.1 Хамрах хүрээ


2016 оны жилийн эцсийн байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт 72.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 27.7 мянган аж ахуйн нэгж буюу 38.4 хувийг худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. (Хүснэгт 1).

ХҮСНЭГТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
ААНБ-ын тоо-бүгд	40 951	48 086	51 938	54 929	59 843	64 301	72 182
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо	19 749	15 897	20 430	21 640	22 793	24 194	27 744
Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь	48.2	33.1	39.3	39.4	38.1	37.6	38.4

Сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо өсөх хандлагатай байна. Үүний дотор худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо мөн адил тасралтгүй өсөж ирсэн.

**ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, бүсээр, хувиар**




Улсын хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2016 онд 27744 болж өмнөх оныхоос 3550 буюу 14.7 хувиар өслөө. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог дүнд эзлэх хувиар авч үзвэл, Баруун бүсэд 8.4 хувь, Хангайн бүсэд 9.0 хувь, Төвийн бүсэд 9.8 хувь, Зүүн бүсэд 3.9 хувь, Улаанбаатар хотод дийлэнх буюу 68.9 хувь нь ногдож байна. (Зураг 1).

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар баруун бүсэд 834 аж ахуйн нэгж, байгууллагатай Ховд аймаг, Хангайн бүсэд 930 аж ахуйн нэгж, байгууллагатай Хөвсгөл аймаг, Төвийн бүсэд 733 аж ахуйн нэгж, байгууллагатай Дундговь аймаг, 683 аж ахуйн нэгж, байгууллагатай Сэлэнгэ аймаг, Зүүн бүсэд 478 аж ахуйн нэгж, байгууллагатай Дорнод аймаг аж ахуйн нэгж, байгууллагын тоогоороо тэргүүлсэн бол Баруун бүсэд 244 аж ахуйн нэгж, байгууллагатай Говь-Алтай аймаг, Хангайн бүсэд 218 аж ахуйн нэгж, байгууллагатай Баянхонгор аймаг, Төвийн бүсэд 200 аж ахуйн нэгж, байгууллагатай Дархан-Уул аймаг, 321 аж ахуйн нэгж, байгууллагатай Говьсүмбэр аймаг, Зүүн бүсэд 258 аж ахуйн нэгж, байгууллагатай Сүхбаатар аймаг хамгийн цөөн аж ахуйн нэгж, байгууллагатай байна.

Худалдааны аж ахуйн нэгж, байгууллагын 94.3 хувийг 1-9 ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 3.0 хувийг, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 1.7 хувийг эзэлж, үлдэх 1.0 хувийг 50-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага байна. (Зураг 2).


ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр, хувиар



2016 онд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага улсын дүнгээр 1-9 ажиллагчтай 26163 байгаагаас 2278 буюу 8.7 хувь Баруун бүсэд, 2408 буюу 9.2 хувь Хангайн бүсэд, 2593 буюу 9.9 хувь Төвийн бүсэд, 1042 буюу 4.0 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 17842 буюу 68.2 хувийг тус тус эзэлж байна. 1-9 ажиллагчтай аж ахуйн нэгж, байгууллагын дотор Ховд, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Увс аймаг бүс болон улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын тоогоороо тэргүүлж байна. (Зураг 3).

Худалдааны салбарт 2016 онд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 10-19 ажиллагчтай 822 аж ахуйн нэгж, байгууллагаас 46 буюу 5.6 хувь Баруун бүсийн, 79 буюу 9.6 хувь Хангайн бүсийн, 85 буюу 10.3 хувь Төвийн бүсийн, 22 буюу 2.7 хувь Зүүн бүсийн, 590 буюу 71.8 хувийг Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллага тус тус эзэлж байна. (Зураг 3).

ЗУРАГ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр, бүсээр, хувиар



**ХҮСНЭГТ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэлээр**

Бүс, аймаг, нийслэл	2010	2011 ¹	2012	2013	2014	2015	2016
БҮГД	19 749	15 897	20 430	21 640	22 793	24 194	27 744
Баруун бүс	858	1 028	1 512	1 692	1 864	2 131	2 340
Баян-Өлгий	170	210	273	312	331	334	346
Говь-Алтай	56	79	159	183	190	225	244
Завхан	50	89	240	265	268	358	408
Увс	206	279	327	354	450	453	508
Ховд	376	371	513	578	625	761	834
Хангайн бүс	1 216	1 254	1 551	1 846	2 042	2 142	2 510
Архангай	120	150	171	190	261	291	315
Баянхонгор	73	88	107	153	164	180	218
Булган	92	145	185	198	262	269	304
Орхон	161	153	759	839	277	276	303
Өвөрхангай	72	129	189	236	287	365	440
Хөвсгөл	698	589	140	230	791	761	930
Төвийн бүс	1 579	1 473	2 050	2 073	2 311	2 475	2 706
Говьсүмбэр	168	137	48	38	255	295	321
Дархан-Уул	134	135	647	590	166	187	200
Дорноговь	219	205	184	194	437	453	498
Дундговь	551	356	166	181	613	672	733
Өмнөговь	71	113	316	339	164	155	177
Сэлэнгэ	394	487	512	554	617	630	683
Төв	42	40	177	177	59	83	94
Зүүн бүс	635	636	741	781	908	967	1 073
Дорнод	234	232	295	315	358	434	478
Сүхбаатар	155	155	175	202	219	236	258
Хэнтий	246	249	271	264	331	297	337
Улаанбаатар	15 461	11 506	14 576	15 248	15 668	16 479	19 115

¹ААНБ-ын 2011 оны тооллогын үр дүнгээр шинэчилсэн бизнес регистрийн санд үндэслэв.

Худалдааны салбарт 2016 онд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас 20-49 ажиллагчтай 484 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 12 буюу 2.5 хувь Баруун бүсэд, 19 буюу 3.9 хувь Хангайн болон Төвийн бүсэд, 8 буюу 1.7 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 426 буюу 88.0 хувийг тус тус эзэлж байна. (Зураг 3).

Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2016 онд 50-аас дээш ажиллагчтай 275 аж ахуйн нэгж байгаагаас 4 буюу 1.4 хувь Баруун болон Хангайн бүсэд, 9 буюу 3.3 хувь Төвийн бүсэд, 1 буюу 0.4 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 257 буюу 93.5 хувийг тус тус эзэлж байна. (Зураг 3).

ХҮСНЭГТ 3. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, 2016 он, бүс, аймаг, нийслэлээр, ажиллагчдын тооны бүлгээр

Бүс, аймаг, нийслэл	Бүгд				
		1-9	10-19	20-49	50+
БҮГД	27 744	26 163	822	484	275
Баруун бүс	2 340	2 278	46	12	4
Баян-Өлгий	346	340	3	2	1
Говь-Алтай	244	240	4	-	-
Завхан	408	399	9	-	-
Увс	508	492	10	5	1
Ховд	834	807	20	5	2
Хангайн бүс	2 510	2 408	79	19	4
Архангай	315	303	8	3	1
Баянхонгор	218	207	10	1	-
Булган	304	298	5	1	-
Орхон	930	913	14	2	1
Өвөрхангай	303	278	18	6	1
Хөвсгөл	440	409	24	6	1
Төвийн бүс	2 706	2 593	85	19	9
Говьсүмбэр	94	88	4	2	-
Дархан-Уул	683	651	26	5	1
Дорноговь	321	307	9	2	3
Дундговь	200	194	4	2	-
Өмнөговь	498	467	24	3	4
Сэлэнгэ	733	714	13	5	1
Төв	177	172	5	-	-
Зүүн бүс	1 073	1 042	22	8	1
Дорнод	478	467	5	5	1
Сүхбаатар	258	250	5	3	-
Хэнтий	337	325	12	-	-
Улаанбаатар	19 115	17 842	590	426	257

ХҮСНЭГТ 4. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар

Салбар	2010	2011 ¹	2012	2013	2014	2015	2016
Бүгд	19 749	15 897	19 646	21 640	22 793	24 194	27 744
Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклын бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	529	645	716	970	1 155	1 221	1 340
Машин, мотоциклоос бусад барааны бөөний худалдаа	6 684	7 745	10 835	11 622	12 382	13 045	15 292
Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа	12 536	7 507	8 095	9 048	9 256	9 928	11 112

¹ААНБ-ын 2011 оны тооллогын үр дүнгээр шинэчилсэн бизнес регистрийн санд үндэслэв.

Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллага 2016 онд 27.7 мянга байгаагийн 1.3 мянга буюу 4.8 хувь нь моторт тээврийн хэрэгсэл, мотоциклын бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний чиглэлээр, 15.3 мянга буюу 55.1 хувь нь бөөний худалдааны чиглэлээр, 11.1 мянга буюу 40.0 хувь нь жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. (Хүснэгт 4).

**ХҮСНЭГТ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, 2016 он, бүс, аймаг,
нийслэлээр дэд салбараар**

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Машин, мотоцикл, түлш шатахууны худалдаа, засвар үйлчилгээ	Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын барааны худалдаа	Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа
БҮГД	27 744	1 340	15 292	11 112
Баруун бүс	2 340	116	544	1 680
Баян-Өлгий	346	45	173	128
Говь-Алтай	244	12	65	167
Завхан	408	11	72	325
Увс	508	23	89	396
Ховд	834	25	145	664
Хангайн бүс	2 510	141	774	1 595
Архангай	315	19	68	228
Баянхонгор	218	9	59	150
Булган	304	6	72	226
Орхон	930	54	323	553
Өвөрхангай	303	19	112	172
Хөвсгөл	440	34	140	266
Төвийн бүс	2 706	126	744	1 836
Говьсүмбэр	94	10	14	70
Дархан-Уул	683	39	166	478
Дорноговь	321	15	53	253
Дундговь	200	19	35	146
Өмнөговь	498	26	149	323
Сэлэнгэ	733	13	255	465
Төв	177	4	72	101
Зүүн бүс	1 073	38	184	851
Дорнод	478	17	103	358
Сүхбаатар	258	5	48	205
Хэнтий	337	16	33	288
Улаанбаатар	19 115	919	13 046	5 150

Өмнөх оныхоос машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 119 буюу 9.7 хувь, машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын барааны худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийнх мөн 2247 буюу 17.2 хувь, машин, мотоцикл, түлш шатахууны худалдаа, засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийнх өмнөх оныхоос 1189 буюу 11.9 хувиар тус тус өссөн байна.

Улсын хэмжээнд 2016 онд машин, мотоцикл, түлш шатахууны худалдаа, засвар үйлчилгээ эрхэлдэг 1340 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 116 буюу 8.7 хувь Баруун бүсэд, 141 буюу 10.5 хувь Хангайн бүсэд, 126 буюу 9.4 хувь Төвийн бүсэд, 38 буюу 2.8 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 919 буюу 68.6 хувь нь ногдож байна. (Хүснэгт 5).

Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа 15292 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 544 буюу 3.5 хувь

Баруун бүсэд, 774 буюу 5.1 хувь Хангайн бүсэд, 744 буюу 4.9 хувь Төвийн бүсэд, 184 буюу 1.2 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 13046 буюу 85.3 хувийг эзэлж байна. (Хүснэгт 5).

Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа 11112 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 1680 буюу 15.1 хувь Баруун бүсэд, 1595 буюу 14.4 хувь Хангайн бүсэд, 1836 буюу 16.5 хувь Төвийн бүсэд, 851 буюу 7.7 хувь Зүүн бүсэд, Улаанбаатар хотод 5150 буюу 46.3 хувийг эзэлж байна. (Хүснэгт 5).

II.2 Ажиллагчдын тоо, дундаж цалин

Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр эзэлдэг үйлчилгээний салбарын нэг юм. Улсын хэмжээнд худалдааны салбарт 2016 онд 172.7 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 15.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 5.5 мянган хүн буюу 3.1 хувиар буурчээ. (Хүснэгт 6).

ХҮСНЭГТ 6. АЖИЛЛАГЧДЫН ТОО

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Нийт ажиллагчид	1 033.7	1 037.7	1 056.4	1 103.6	1 110.7	1 151.2	1 147.8
Худалдааны салбарт	146.2	152.5	131.3	156	170.2	178.2	172.7
Худалдааны салбарын эзлэх хувь (%)	14.1	14.7	12.4	14.1	15.3	15.5	15.0

Нийт ажиллагчдын тоог 2010 оныхтой харьцуулахад 114.1 мянган хүн буюу 11.0 хувь, худалдааны салбарт ажиллагчдын тоо 26.5 мянган хүн буюу 18.1 хувиар өсжээ. Худалдааны салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 2015 оныхоос 0.5 пунктээр буурсан байна. (Хүснэгт 6).

ЗУРАГ 4. НИЙТ АЖИЛЛАГЧДЫН БОЛОН ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, ЖИЛИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ



Нийт ажиллагчдын тоо 2010-2015 онд тогтвортой өссөн бөгөөд 2016 онд нийт ажиллагчдын тоо 0.3 хувиар буурчээ. Худалдааны салбарт ажиллагчдын тоо 2011 болон

2013-2015 онуудад өсөж байсан бол 2010 онд 8.8 хувь, 2012 онд 13.9 хувь, 2016 онд 3.1 хувиар тус тус буурчээ. (Зураг 4).

ХҮСНЭГТ 7. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2010	2011 ¹	2012	2013	2014	2015	2016
БҮГД	19 749	15 897	20 430	21 640	22 793	24 194	27 744
Баруун бүс	858	1 028	1 512	1 692	1 864	2 131	2 340
Баян-Өлгий	170	210	273	312	331	334	346
Говь-Алтай	56	79	159	183	190	225	244
Завхан	50	89	240	265	268	358	408
Увс	206	279	327	354	450	453	508
Ховд	376	371	513	578	625	761	834
Хангайн бүс	1 216	1 254	1 551	1 846	2 042	2 142	2 510
Архангай	120	150	171	190	261	291	315
Баянхонгор	73	88	107	153	164	180	218
Булган	92	145	185	198	262	269	304
Орхон	161	153	759	839	277	276	303
Өвөрхангай	72	129	189	236	287	365	440
Хөвсгөл	698	589	140	230	791	761	930
Төвийн бүс	1 579	1 473	2 050	2 073	2 311	2 475	2 706
Говьсүмбэр	168	137	48	38	255	295	321
Дархан-Уул	134	135	647	590	166	187	200
Дорноговь	219	205	184	194	437	453	498
Дундговь	551	356	166	181	613	672	733
Өмнөговь	71	113	316	339	164	155	177
Сэлэнгэ	394	487	512	554	617	630	683
Төв	42	40	177	177	59	83	94
Зүүн бүс	635	636	741	781	908	967	1 073
Дорнод	234	232	295	315	358	434	478
Сүхбаатар	155	155	175	202	219	236	258
Хэнтий	246	249	271	264	331	297	337
Улаанбаатар	15 461	11 506	14 576	15 248	15 668	16 479	19 115

¹ААНБ-ын 2011 оны тооллогын үр дүнгээр шинэчилсэн бизнес регистрийн санд үндэслэв.

Худалдааны салбарын ажиллагчид 2016 онд 172.7 мянга болсноос Баруун бүсэд 18.6 мянга буюу 10.8 хувь, Хангайн бүсэд 19.0 мянга буюу 11.0 хувь, Төвийн бүсэд 23.4 мянга буюу 13.5 хувь, Зүүн бүсэд 8.3 мянга буюу 4.8 хувь, Улаанбаатар хотод 103.4 мянга буюу 59.9 хувийг тус тус эзэлж байна. (Хүснэгт 7).

Бүсийн хэмжээнд ажиллагчдынхаа тоогоор Баруун бүсэд Баян-Өлгий аймаг, Хангайн бүсэд Хөвсгөл аймаг, Төвийн бүсэд Өмнөговь аймаг, Зүүн бүсэд Дорнод аймаг тэргүүлж байна. (Хүснэгт 7).

ЗУРАГ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН



¹ 2000-2013 онд ажиллагчдын сарын дундаж цалингийн мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан түүвэр судалгааны үр дүнгээр тооцож байсан бол 2014 оноос эхлэн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн тооцдог болсон.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаар 2016 онд 861.9 мянга болж өмнөх оныхоос 53.9 мянгаар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн салбарт ажиллагчдын цалин өмнөх оныхоос 47.2 төгрөгөөр буюу 6.8 хувиар өсчээ. (Зураг 5).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчдын цалин 742.5 мянга болж, улсын дунджаас 119.4 мянган төгрөгөөр доогуур байна. (Хүснэгт 8).

Баруун бүсэд 397.9 мянга болж өмнөх оныхоос 45.4 төгрөг, Хангайн бүсэд 402.2 мянга болж 11.2 төгрөг, Төвийн бүсэд 488.1 мянга болж 32.2 төгрөг, Улаанбаатар хотод 822.3 мянга болж 60.0 төгрөгөөр тус тус өсч, харин Зүүн бүсэд 354.1 мянга болж өмнөх оныхоос 9.9 төгрөгөөр буурсан байна. (Хүснэгт 8).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчдаас бүс болон улсын хэмжээнд хамгийн өндөр цалинтай нь Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул аймаг, харин хамгийн бага цалинтай нь Сүхбаатар, Завхан, Хэнтий, Булган, Дундговь аймагт байна. (Хүснэгт 8).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын ажиллагчдын цалингийн өсөлтийг бүсийн түвшинд авч үзвэл, Баруун бүсийн дундаж цалин 2016 онд 397.9 мянга байхад Говь-Алтай аймагт 525.9 мянга болж, бүсийнхээ дундаж цалингаас 128.0 мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 402.2 мянга байхад Орхон аймагт

450.2 мянга болж, бүсийнхээ дундаж цалингаас 48.0 мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 488.1 мянга байхад Дорноговь аймагт 618.0 мянга болж бүсийнхээ дундаж цалингаас 129.9 төгрөгөөр, Улаанбаатар хотод 822.3 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 79.8 мянган төгрөгөөр тус тус өндөр байна. (Хүснэгт 8).

ХҮСНЭГТ 8. БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ЦАЛИН, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2014	2015	2016
БҮГД	680.5	695.3	742.5
Баруун бүс	336.1	352.5	397.9
Баян-Өлгий	456.4	341.5	354.3
Говь-Алтай	364.7	396.5	525.9
Завхан	364.3	297.1	323.1
Увс	254.1	332.3	348.6
Ховд	357.2	355.3	383.1
Хангайн бүс	361.1	391.0	402.2
Архангай	262.3	272.2	322.9
Баянхонгор	312.7	407.7	426.5
Булган	323.1	357.6	327.3
Орхон	394.7	445.8	450.2
Өвөрхангай	369.8	368.7	419.5
Хөвсгөл	338.3	332.8	341.6
Төвийн бүс	437.6	455.9	488.1
Говьсүмбэр	513.9	460.6	474.4
Дархан-Уул	422.8	432.3	467.9
Дорноговь	752.3	631.7	618.0
Дундговь	313.8	337.3	340.6
Өмнөговь	346.7	457.2	561.7
Сэлэнгэ	363.3	386.7	378.5
Төв	383.5	389.4	465.4
Зүүн бүс	377.1	364.0	354.1
Дорнод	384.6	380.2	393.8
Сүхбаатар	371.9	352.1	299.7
Хэнтий	284.5	335.4	325.3
Улаанбаатар	753.3	762.3	822.3

II.3 Нийт борлуулалт

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тухайн хугацааны турш гадагш худалдсан бараа буюу үзүүлсэн ажил, үйлчилгээний хэмжээ байдаг.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2016 онд 16773.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 925.1 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар буурлаа. Албан секторын нийт борлуулалт 2016 онд 14.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 364.3 тэрбум төгрөг буюу 2.5 хувь, албан бус секторын нийт борлуулалт 2.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх

оныхоос 560.8 тэрбум төгрөг буюу 19.5 хувиар тус тус буурчээ. Нийт борлуулалтын дүнд эзлэх хувийг үзэхэд албан сектор 86.2 хувь, албан бус сектор 13.8 хувийг тус тус эзэлж байна. (Хүснэгт 9).

ХҮСНЭГТ 9. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ

Он	Нийт борлуулалт тэрбум төгрөг	Нийт борлуулалт		Дүнд эзлэх хувь	Дүнд эзлэх хувь	
		Албан сектор	Албан бус сектор		Албан сектор	Албан бус сектор
2010	4 918.7	3 432.7	1 486.0	100.0	69.8	30.2
2011	9 602.1	7 762.1	1 840.0	100.0	80.8	19.2
2012	13 350.0	10 775.7	2 574.2	100.0	80.7	19.3
2013	14 456.4	11 896.7	2 559.7	100.0	82.3	17.7
2014	16 980.5	14 098.1	2 964.7	100.0	82.4	17.6
2015	17 698.7	14 816.3	2 882.4	100.0	83.7	16.3
2016 ¹	16 773.6	14 452.0	2 321.6	100.0	86.2	13.8

¹ Урьдчилсан гүйцэтгэл

II.4 Нийт үйлдвэрлэл

Худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийг бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажилчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-ыг оруулж тооцдог.

Худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ /цэвэр татварыг хассанаар/ 2016 онд 4087.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 58.7 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар буурсан байна. (Хүснэгт 10).

Худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийн 1914.9 тэрбум төгрөг буюу 46.8 хувь нь бөөний худалдааны салбарт, 2172.8 тэрбум төгрөг буюу 53.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна. (Хүснэгт 10).

ХҮСНЭГТ 10. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ /цэвэр татварыг хассанаар/, оны үнээр

Он	Бүгд тэрбум төгрөг	Дүнд		Бөөний худалдаа	Жижиглэнгийн худалдаа
		эзлэх хувь	эзлэх хувь		
2010	1 514.0	944.3	569.7	100.0	37.6
2011	2 015.2	1 212.2	803.0	100.0	39.8
2012	2 732.2	1 397.1	1 335.1	100.0	48.9
2013	3 201.4	1 685.0	1 516.4	100.0	47.4
2014	3 929.5	1 883.4	2 046.1	100.0	52.1
2015	4 146.4	2 211.7	1 934.7	100.0	46.7
2016	4 087.7	1 914.9	2 172.8	100.0	53.2

II.5 Нэмэгдэл өртөг

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийг оны үнээр тооцох үндсэн арга нь нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээ буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардлыг хасаж тооцдог үйлдвэрлэлийн арга байдаг.

Дотоод худалдааны салбар нь манай орны эдийн засагт томоохон байр эзэлдэг үйлчилгээний салбарын нэг бөгөөд 2016 онд ДНБ-ий 11.3 хувийг эзэлж байна. 2016 онд дотоодын нийт бүтээгдэхүүн улсын дүнгээр 23886.4 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос 736.0 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар өсжээ. (Хүснэгт 11).

ХҮСНЭГТ 11. НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ХЭМЖЭЭ, оны үнээр

	2010	2011	2012	2013	2014	2015	2016 ¹
	тэрбум төг						
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	22 227.1	23 150.4	23 886.4
Худалдааны салбарын нэмэгдэл өртөг	1 199.0	1 973.3	2 231.1	2 267.2	2 544.8	2 670.3	2 705.1
ДНБ-д худалдааны салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь	12.3	15.0	13.4	11.8	11.4	11.5	11.3

Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2016 онд оны үнээр 2705.1 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 34.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2010 оныхоос 2.4 дахин өссөн байна. (Хүснэгт 11).

**ХҮСНЭГТ 12. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН
ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ
бүс, аймаг, нийслэлээр, тэрбум төгрөгөөр**

Бүс, аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016 ¹
ДНБ	9 756.6	1 173.8	166 688.4	19 174.2	22 227.1	23 150.4	23 886.4
БҮГД	1 199.0	1 973.3	2 231.1	2 267.2	2 544.8	2 670.3	2 705.1
Баруун бүс	55.5	85.6	86.5	93.0	114.5	111.3	105.2
Баян-Өлгий	12.1	22.8	23.6	24.6	31.9	30.0	31.7
Говь-Алтай	13.9	12.6	10.0	8.7	11.2	10.7	9.9
Завхан	12.4	21.4	22.3	25.1	28.9	29.3	23.5
Увс	8.9	14.9	16.2	18.4	23.1	21.2	23.5
Ховд	8.1	13.8	14.3	16.3	19.4	20.2	16.6
Хангайн бүс	58.3	89.8	98.9	121.1	137.6	140.9	115.8
Архангай	3.4	5.1	5.5	7.0	8.0	10.6	8.2
Баянхонгор	8.4	12.9	13.8	16.5	19.3	18.9	16.2
Булган	1.0	1.6	1.9	2.3	3.4	3.9	2.2
Орхон	23.2	34.1	38.5	47.4	51.0	43.7	40.1
Өвөрхангай	8.1	13.8	15.7	17.6	21.3	20.0	19.9
Хөвсгөл	14.1	22.3	23.5	30.3	34.6	43.9	29.2
Төвийн бүс	49.5	83.9	91.3	104.0	140.6	128.2	108.4
Говьсүмбэр	0.2	1.8	0.9	2.9	9.3	9.1	3.1
Дархан-Уул	15.9	28.8	35.3	37.3	50.5	42.6	37.9
Дорноговь	5.1	11.4	9.4	11.3	14.0	15.5	14.2
Дундговь	3.2	4.2	5.4	7.3	7.7	7.1	6.4
Өмнөговь	7.0	11.9	12.9	14.6	18.7	17.9	18.2
Сэлэнгэ	12.1	16.2	17.7	20.3	25.8	24.1	18.5
Төв	6.0	9.6	9.8	10.3	14.5	11.8	10.1
Зүүн бүс	12.0	19.8	21.2	30.2	34.8	42.7	27.4
Дорнод	5.0	9.5	9.3	13.9	16.8	25.3	11.0
Сүхбаатар	1.2	1.4	1.9	3.3	4.2	3.5	4.5
Хэнтий	5.8	8.9	9.9	13.1	13.8	13.9	11.9
Улаанбаатар	1 023.8	1 694.1	1 933.3	1 918.9	2 117.3	2 247.1	2 348.3

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 2010-2016 онд тогтвортой өссөн байна. (Хүснэгт 12).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 2016 онд 2705.1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос 34.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсжээ. (Хүснэгт 12).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн дүнд эзлэх хувийг бүсийн дүнгээр үзүүлбэл Баруун бүсэд 105.2 буюу 3.9 хувь, Хангайн бүсэд 115.8 буюу 4.3 хувь, Төвийн бүсэд 108.4 буюу 4.0 хувь, Зүүн бүсэд 27.4 буюу 1.0 хувь, Улаанбаатар хотод 2348.3 буюу 86.8 хувийг эзэлж байна. (Хүснэгт 12).

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийнхөө хэмжээгээр Орхон, Дархан-Уул, Баян-Өлгий, Хөвсгөл, Увс аймгууд тэргүүлж байна. (Хүснэгт 12).

II.6 Хөдөлмөрийн бүтээмж

Хөдөлмөрийн бүтээмжийг худалдааны салбарын нэмэгдэл өртгийг ажиллагчдын тоонд харьцуулж тооцдог.

Нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг буюу худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж 2016 онд 15.7 сая төгрөг болж, 2015 оныхоос 0.7 сая төгрөг, 2010 оныхоос 7.5 сая төгрөгөөр өссөн байна. (Хүснэгт 13).

ХҮСНЭГТ 13. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөгөөр

Бүс, аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016
БҮГД	8.2	12.9	17.0	14.5	14.9	15.0	15.7
Баруун бүс	3.8	4.8	5.8	5.4	6.1	5.2	5.7
Баян-Өлгий	3.9	5.0	7.8	5.4	5.4	5.4	5.1
Говь-Алтай	4.7	4.7	4.2	3.5	4.3	3.1	5.6
Завхан	9.9	9.6	8.9	10.2	6.9	7.6	9.6
Увс	2.2	3.4	4.0	5.0	12.6	6.6	8.5
Ховд	2.6	3.4	4.9	4.1	4.4	3.8	3.1
Хангайн бүс	3.1	3.8	4.9	6.1	6.4	6.7	6.1
Архангай	0.7	1.5	2.8	1.8	5.0	5.2	2.9
Баянхонгор	3.2	3.4	6.2	9.3	6.7	7.2	5.2
Булган	1.1	1.4	3.0	1.9	2.7	3.5	3.4
Орхон	6.7	5.9	7.2	10.3	7.5	6.4	9.3
Өвөрхангай	1.9	3.4	4.2	4.1	4.2	3.8	6.5
Хөвсгөл	4.7	4.2	3.6	7.1	8.8	13.8	5.7
Төвийн бүс	1.9	3.9	5.1	4.7	5.9	5.0	4.6
Говьсүмбэр	0.3	1.9	3.0	5.5	13.9	7.9	1.1
Дархан-Уул	2.4	3.7	6.0	5.7	7.7	7.0	16.2
Дорноговь	1.5	8.0	3.7	3.3	4.1	4.2	5.1
Дундговь	1.2	1.8	3.1	3.6	3.2	2.9	1.5
Өмнөговь	1.8	6.6	9.4	6.4	5.8	4.0	3.6
Сэлэнгэ	1.9	3.7	4.5	5.2	7.3	7.0	3.6
Төв	2.4	3.6	4.5	3.2	3.6	2.6	12.0
Зүүн бүс	2.1	2.9	4.0	3.9	3.4	3.9	3.3
Дорнод	3.5	4.8	3.7	4.7	6.1	5.9	3.1
Сүхбаатар	0.5	0.6	1.0	2.4	1.2	1.0	1.6
Хэнтий	2.9	3.5	10.4	3.8	3.4	4.3	6.5
Улаанбаатар	12.7	20.5	26.5	21.5	22.2	22.7	22.7

Худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж Баруун бүсэд 5.7 сая төгрөг, Хангайн бүсэд 6.1 сая төгрөг, Төвийн бүсэд 4.6 сая төгрөг, Зүүн бүсэд 3.3 сая төгрөг, Улаанбаатарт 22.7 сая төгрөг байна. (Хүснэгт 13).

2016 онд худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж 15.7 сая төгрөг, Дархан-Уул аймагт 16.2 сая төгрөг, Төв аймагт 12.0 сая төгрөг, Завхан аймагт 9.6 сая төгрөг, Орхон аймагт 9.3 сая төгрөг, Увс 8.5 сая төгрөг байна. (Хүснэгт 13).

II.7 Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо 2016 оны жилийн эцэст улсын дунджаар 50 хүн, Баруун бүсэд 76 хүн, Хангайн бүсэд 74, Төвийн бүсэд 53, Зүүн бүсэд 56 хүн, Улаанбаатарт 39 хүн байна. (Хүснэгт 14).

ХҮСНЭГТ 14. ХУДАЛДААНЫ НЭГ ЦЭГТ НОГДОХ ХҮНИЙ ТОО, бүс, аймаг, нийслэлээр, ОНЫ ЭЦЭСТ

Бүс, аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016 ¹
БҮГД	53	47	46	50	52	52	50
Баруун бүс	74	69	68	71	87	84	76
Баян-Өлгий	64	59	76	73	97	102	91
Говь-Алтай	93	87	134	180	140	128	89
Завхан	54	52	43	49	50	47	59
Увс	89	81	63	75	168	177	101
Ховд	90	83	77	65	72	66	59
Хангайн бүс	76	65	64	60	67	71	74
Архангай	124	117	291	211	216	206	216
Баянхонгор	77	70	55	41	75	74	71
Булган	89	74	77	78	78	77	106
Орхон	34	29	27	29	32	34	31
Өвөрхангай	88	62	60	64	49	59	94
Хөвсгөл	153	142	145	111	143	133	105
Төвийн бүс	60	47	47	54	54	53	53
Говьсүмбэр	47	34	36	38	28	28	28
Дархан-Уул	56	34	42	36	48	48	57
Дорноговь	46	38	40	45	45	44	48
Дундговь	72	51	50	49	73	71	54
Өмнөговь	101	64	50	80	45	46	38
Сэлэнгэ	48	50	52	60	47	45	50
Төв	85	77	52	99	133	134	108
Зүүн бүс	80	59	50	59	63	63	56
Дорнод	72	55	48	51	53	51	52
Сүхбаатар	66	63	91	89	96	96	73
Хэнтий	80	59	39	53	58	61	50
Улаанбаатар	41	38	37	41	41	41	39

¹ Урьдчилсан гүйцэтгэл

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо улсын дүнгээр 2016 оны жилийн эцэст 50 болж, өмнөх оныхоос 2 хүнээр буурчээ.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоогоороо улсын дунджаас Архангай аймаг 166, Төв аймаг 58, Булган аймаг 56, Хөвсгөл аймаг 55, Увс аймаг 51 хүнээр их байна.

Дүгнэлт

2016 оны жилийн эцсийн байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт 72.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 27.7 мянган аж ахуйн нэгж буюу 38.4 хувийг худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр эзэлдэг үйлчилгээний салбарын нэг юм. Улсын хэмжээнд худалдааны салбарт 2016 онд 172.7 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 15.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 5.5 мянган хүн буюу 3.1 хувиар буурчээ.

Нийт ажиллагчдын тоог 2010 оныхтой харьцуулахад 114.1 мянган хүн буюу 11.0 хувь, худалдааны салбарт ажиллагчдын тоо 26.5 мянган хүн буюу 18.1 хувиар өсжээ. Худалдааны салбарт ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 2015 оныхоос 0.5 пунктээр буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаар 2016 онд 861.9 мянган төгрөг болж өмнөх оныхоос 53.9 мянгаар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн салбарт ажиллагчдын цалин өмнөх оныхоос 47.2 мянган төгрөгөөр өсжээ. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчдын цалин 742.5 мянган төгрөг болж улсын дунджаас 119.4 мянган төгрөгөөр доогуур байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2016 онд 16773.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 925.1 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар буурлаа.

Худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2016 онд 4087.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 58.7 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлд албан сектор 65.9 хувь, албан бус сектор 34.1 хувийг эзэлж байна.

2016 онд худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ оны үнээр 2705.1 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 34.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өссөн байна. Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2010 оныхоос 2.4 дахин өссөн байна.

2016 онд худалдааны салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 11.3 байна.

Нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг буюу худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж 2016 онд 15.7 сая төгрөг болж, 2015 оныхоос 0.7 сая төгрөгөөр өслөө.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо 2016 оны жилийн эцэст улсын дунджаар 50 хүн, Баруун бүсэд 76 хүн, Хангайн бүсэд 74, Төвийн бүсэд 53, Зүүн бүсэд 56 хүн, Улаанбаатарт 39 хүн байна.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоогоороо улсын дунджаас Архангай аймаг 166, Төв аймаг 58, Булган аймаг 56, Хөвсгөл аймаг 55, Увс аймаг 51 хүнээр их байна.